



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр

**Зээлийн дугаар ба нэр:** L35490-MON: Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл

**Гэрээний дугаар ба нэр:** FR-03: 3 ээлжээр хичээллэх эрсдэлтэй сургуулийн ачааллыг бууруулахад шаардлагатай ширээ, сандал, тавилга, хэрэгсэл нийлүүлэх

- 1. Монгол Улс нь Азийн Хөгжлийн Банкнаас “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан ба энэхүү зээлийн хөрөнгийн тодорхой хэсгийг *FR-03 дугаартай 3 ээлжээр хичээллэх эрсдэлтэй сургуулийн ачааллыг бууруулахад шаардлагатай ширээ, сандал, тавилга, хэрэгсэл нийлүүлэх гэрээг* санхүүжүүлэхэд зарцуулна.**
- 2. Боловсрол, шинжлэх ухааны яам нь эрх бүхий тендерт оролцогчдоос 3 ээлжээр хичээллэх эрсдэлтэй сургуулийн ачааллыг бууруулахад шаардлагатай ширээ, сандал, тавилга, хэрэгсэл нийлүүлэх зорилгоор битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.**
- 3. Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтыг АХБ-ны нэг шаттай, нэг дугтуйт горимын дагуу явуулах бөгөөд эрх бүхий орны харьяат нийт тендерт оролцогчдод нээлттэй байна.**
- 4. Энэхүү тендер шалгаруулалтад зөвхөн дор дурдсан чадварын үндсэн шаардлагыг хангасан эрх бүхий тендерт оролцогч оролцоно. Үүнд:**

### Жилийн дундаж борлуулалт

Сүүлийн 3 жилд (2020, 2021, 2022) гүйцэтгэж дууссан эсхүл гүйцэтгэж байгаа гэрээний жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ нь:

- 1. FR-03/01: 1,182,000,000 (нэг тэрбум нэг зуун наян хоёр сая) төгрөг**
- 2. FR-03/02: 4,130,000,000 (дөрвөн тэрбум нэг зуун гучин сая) төгрөг**
- 3. FR-03/03: 154,000,000 (нэг зуун тавин дөрвөн сая) төгрөгөөс** багагүй байна.

Энэ хэмжээг тендерт оролцогчийн сүүлийн гурван жилд гүйцэтгэж дууссан эсхүл гүйцэтгэж буй гэрээний хүрээнд хийгдсэн нийт төлбөрийн хэмжээгээр тодорхойлно.

### Гэрээний туршлага

Сүүлийн 3 жилд (2020, 2021, 2022) үндсэн гүйцэтгэгчээр амжилттай ажиллаж дуусгасан бараа нийлүүлсэн хамгийн багадаа 1 гэрээ хэрэгжүүлсэн туршлагатай байна. Гэрээний үнийн дундаж хэмжээ нь:

- 1. FR-03/01: 740,000,000 (долоон зуун дөчин сая) төгрөг**
- 2. FR-03/02: 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая) төгрөг**
- 3. FR-03/03: 77,000,000 (далан долоо сая) төгрөгөөс** багагүй байна.

Гэрээний агуулга ба иж бүрдэл нь нэрлэсэн тендертэй ижил байна.

### Мөнгөн гүйлгээний чадавх

Гэрээний хэрэгжилтийн явцад шаардлагатай мөнгөн гүйлгээний хэрэгцээг хангаж чадах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, авах боломжтой зээл, эсхүл бусад санхүүжилтийн нийт хэмжээ нь:

- 1. FR-03/01: 443,452,000.00 (дөрвөн дөчин гурван мянга дөрвөн зуун тавин хоёр мянга ) төгрөг**

2. FR-03/02: **1,549,200,000.00** (*хоёр тэрбум таван зуун сая*) **төгрөг**
3. FR-03/03: **58,000,000.00** (*далан долоо сая*) **төгрөг** буюу түүнээс дээш байна.
  
5. Сонирхсон эрх бүхий тендерт оролцогч нь **Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслөөс** нэмэлт мэдээлэл авч, **8:30 цагаас 17:30 цаг хүртэлх** цагийн хооронд урилгын төгсгөлд заасан хаягт хүрэлцэн ирж тендерийн баримт бичигтэй танилцаж болно.
6. Сонирхсон тендерт оролцогч нь урилгын төгсгөлд заасан хаягт хандан бичгээр хүсэлтээ гаргаж **250,000** (*хоёр зуун тавин мянга*) **төгрөг** төлсөнөөр Монгол хэл дээр бэлтгэгдсэн тендерийн баримт бичгийг худалдан авч болно. Төлбөрийг **Төрийн сангийн 100900011858** тоот дансанд шилжүүлсэн байна. Тендерийн баримт бичгийг урилгын төгсгөлд заасан хаягаар ирж авна.
7. Тендерийг **2023 оны 10 дугаар сарын 16 -ны өдрийн 11:00 цагт** эсхүл түүнээс өмнө урилгын төгсгөлд заасан хаягаар ирүүлнэ. Тендерийн хамт
  1. FR-03/01: 15,000,000 (арван таван сая) төгрөг.
  2. FR-03/02: 52,000,000 (тавин хоёр сая) төгрөг.
  3. FR-03/03: 2,000,000 (хоёр сая) төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгааг **тус тус** ирүүлнэ.Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана. Тендерийг **2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 11:00 цагт** урилгын төгсгөлд заасан хаягт заасан байршилд нээх ба, нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ.
8. Тендер бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор тендерт оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг **Боловсрол, шинжлэх ухааны яам** хариуцахгүй.

**Байгууллагын нэр:** Боловсрол, шинжлэх ухааны яаман дээр хэрэгжиж буй Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төсөл

**Байгууллагын хаяг:** Бага тойруу-1, 8-р хороо, Сити центр

**Давхар ба өрөөний дугаар:** 8 давхар, 802 тоот

**Хот дүүрэг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

**Улс:** Монгол Улс

**Утас:** 976-77660888

**Цахим шуудан:** [bayarnaadam@eduproject.mn](mailto:bayarnaadam@eduproject.mn), [battuya@eduproject.mn](mailto:battuya@eduproject.mn)